



МОНГОЛ УЛСЫН
ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙДЫН
ТУШААЛ

2020 оны 01 сарын 09 өдөр

Дугаар 4703

Улаанбаатар хот

Дипломат албан тушаал эрхлэх
болзол батлах тухай

Төрийн албаны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, 23 дугаар зүйлийн 23.1, 25 дугаар зүйлийн 25.1, Дипломат албаны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Дипломат албан тушаал эрхлэх болзол”-ыг хавсралт ёсоор баталсугай.
2. Энэ тушаалын хэрэгжилтийг хангах, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга, Төрийн албаны зөвлөлийн Гадаад харилцааны яамны дэргэдэх Салбар зөвлөлийн дарга Д.Даваасүрэнд үүрэг болгосугай.
3. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Болзол батлах тухай Гадаад харилцааны сайдын 2010 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн А/37 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.


САЙД



Д.ЦОГТБААТАР

080524

Гадаад харилцааны сайдын
2020 оны 01 дүгээр сарын 09-ны өдрийн
103 дугаар тушаалын хавсралт



ДИПЛОМАТ АЛБАН ТУШААЛ ЭРХЛЭХ БОЛЗОЛ

Нэг. Дипломат албан тушаалд томилох нийтлэг журам

Дипломат албан тушаалд Төрийн албаны тухай, Дипломат албаны тухай хуулиар тогтоосон нийтлэг болон тусгай шаардлагыг хангасан Монгол Улсын иргэнийг сонгон шалгаруулж томилно.

Хоёр. Дипломат албан тушаалд томилох үндсэн шалгуур

2.1 Төрийн албаны тухай хуулийн 3.1.3-т заасан чадахуйн зарчим, Дипломат албаны тухай хуулийн 15.2, 15.3-т заасан болзлыг үндсэн шалгуур болгож, түүнийг бүрэн хангасан хүнийг дипломат албан тушаалд томилно.

2.2 Дипломат албан тушаалд тавигдах нийтлэг болон тусгай шаардлагыг хангасан тохиолдолд чадахуйн зарчмыг бүрэн хангасанд тооцно.

Гурав. Дипломат албан тушаалд тавигдах нийтлэг шаардлага

Төрийн албаны тухай хуулийн 22 дугаар зүйлд заасан нийтлэг шаардлага болон Дипломат албаны тухай хуулийн 15.2-т заасан "олон улсын эрх зүй, эдийн засаг, улс төрийн харилцааны онолын зохих бэлтгэлтэй, дадлага туршлагатай, дээд боловсролтой" байх болзлыг хангасан иргэнийг дипломат албан тушаалд тавигдах нийтлэг шаардлагыг хангасанд тооцно.

Дөрөв. Дипломат албан тушаалд тавигдах тусгай шаардлага

4.1 Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлд заасан тусгай шаардлагаас гадна дараахь тусгай шаардлагыг хангасан иргэнийг дипломат албан тушаалд томилно:

4.1.1 Дипломат албаны тухай хуулийн 15.2-т заасан "2 буюу түүнээс дээш гадаад хэлийг шаардлагын түвшинд эзэмшсэн байх бөгөөд нэг нь түгээмэл гадаад хэл байх" болзлыг хангасан байх;

4.1.2 Дипломат албаны тухай хуулийн 15.3-т заасан тохиолдолд "түгээмэл нэг гадаад хэл эзэмшсэн" байх болзлыг хангасан байх;

4.1.3 Тухайн албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлагыг бүрэн хангасан байх;

4.1.4 Төрийн жинхэнэ албаны тусгай шалгалт буюу Дипломат албаны мэргэшлийн шалгалт өгч тэнцсэн байх;

4.1.5 Нөхөр, эхнэр нь гадаад улсын иргэншил болон харьяалалгүй, Монгол Улсын иргэн байх.